



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/22

Жаргалант сум

Боловсрол хөтөлбөрийн 2024 оны
биелэлтийг дүгнэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

Тус сумын “Боловсрол” хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг 90 хувь “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

1024810086

**БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, 3 ЦЭЦЭРЛЭГ
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2024.12.20

Жаргалант

№	Зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн үзүүлэлт			Санхүүжилт		Хүрсэн түвшин, үр дүн	Хувь
			Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин 2024	Санхүүжилт Сая.төг	Санхүү-жилтийн эх үүсвэрийн ангилал		
НЭГ. БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГОЛ ХӨДӨЛГӨГЧ ХҮЧИН БОЛСОН БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ,ЗААХ АРГА ЗҮЙН УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ									
1. Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр:									
1	Ахлах ангиудын дунд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилготой амьдралд бэлэн" сургалт зохион байгуулах.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувир	2023 он	2023 онд 69 сурагч	100%	-	ОНТ	Засаг даргын Тамгын газартай хамтран "Мэргэжлийн чиг баримжаа олгох аялал"-ыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд 2024 онд 69 сурагч хамрагдсан. Уг үйл ажиллагаанд ахлах ангийн сурагчдыг хамруулснаар мэргэжлээ зөв оновчтой сонгох, сурагчид өөрсдийн хүссэн мэргэжлээ эзэмшиж түүндээ эзэн болох цаашлаад сургуулиа төгсөөд ажиллах боломжтой ажлын байрны талаарх мэдээлэл өгсөн.	100%
2	Цахим орчинд багш өөрийгөө хөгжүүлэх, арга туршлагаа түгээн дэлгэрүүлэх, цахимаар хичээл заах, уралдаан тэмцээнд сурагчдыг оролцох, туршлагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2019, 2023 он	ЕБС, СӨБ багш ажилчид Улаанбаат ар хотруу туршлага судалсан.	Төлөвлөгө өний дагуу туршлага судалсан 100%	-	ОНТ	БШУС-ын 2023 оныг "Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарлах тухай" А/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэн ажиллах ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургууль хооронд "Хамтран ажиллах гэрээ"	100%

<p>Түгээн Дэлгэрүүлэх үйл ажиллагаанд Дэмжлэг үзүүлэх "Багш солилцоо - 2024" зохион байгуулах</p>						<p>байгуулагдсан. Уг гэрээний 2 дугаар зүйлийн 2.2-т заасан хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг Орхон аймгийн IV сургуультай хамтран гаргаж "Багш солилцоо-2023" хөтөлбөрийг 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгаж 3 судлагдахуун хичээлээр 6 багш 2023-11.27-12.01- ны өдрүүдэд арга зүй, туршлагаа түгээн дэлгэрүүлэн ажилласан. Багш солилцоо хөтөлбөрөөр дунд, ахлах ангийн нийт 11 бүлгийн 275 сурагч англи хэл, математик, монгол хэлний хичээл болон давтлага зохион байгуулсан.</p> <p>12а анги- 20 сурагчид</p> <ul style="list-style-type: none"> ✓ Математикийн хичээлээр-8 цаг ✓ Англи хэлний хичээлээр- 4 цагийн давтлага <p>6-8 ангиудад 98 сурагч 2 судлагдахуун хичээлээр 10 цагийн давтлага тус тус орсон. Багш солилцоогоор ирсэн багш нар ҮЗҮҮЛЭХ БОЛОН СУДАЛГААТ хичээл зааж туршлага солилцсон. Нийт сурагчдын 65% давтлагад хамрагдаж, нийт багш нарын 60% нь хамтын оролцоонд хамтран ажилласан байна.</p> <p>3-р цэцэрлэг нь БШУГ-6, Боловсролын газраас ирсэн 8, нийт 14 контентуудыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт "Цэцэрлэгийн фэйсбүүк" групп, 6 бүлгийн групп</p>
---	--	--	--	--	--	--

	2021-2024 оны ЭЕШ-ын гүйцэтгэлийн оноо судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөний дагуу сорил болон үе давтлагыг шаттайгаар зохион байгуулах.	2023 он	2023 он ЭЕШ-ын дундаж оноо	2024 онд ЭЕШ Дундаж оноог 510 болгох			<p>чугаар өгч, мэдээ мэдээлэл солилцон ажилласан нийт 328 эцэг эхэд мэдээлэл хүргэн ажилсан. Ингэснээр эцэг эхийн оролцоо 2,8 хувиар ахисан буюу 38 эцэг нэмэгдсэн. 2024 оны хичээлийн жилд багш нарын "Цахим хичээлийн" сан сургалтын 6 чиглэлээр 48 төрлийн сургалтын материалаар баяжигдсан бөгөөд 2023 онтой харьцуулахад 7,5% нэмэгдсэн. Удирдах ажилчид болон 7 багш, нийт 9 багш удирдах ажилтан нар APLUS модуль цахим сургалтад хамрагдсан. 3 төрлийн цахим контент бэлтгэх уралдаанд оролцож "Усаа хэмнэе", "Хүүхдийн аюулгүй орчин", "Халтирч унахаас болгоомжилъё" 3 сэдвээр 7 18 ширхэг контент бэлтгэн эцэг эх, асран хамгаалагч нарт цахим зөвлөгөөг хүргэн ажилсан.</p>	
3		2023 он	2023 он ЭЕШ-ын дундаж оноо	2024 онд ЭЕШ Дундаж оноог 510 болгох			<p>Тус хичээлийн жилд ЭЕШ-ын сорилыг 3 удаа зохион байгуулсан. Цахим сорил нь 7 судлагдахуун хичээлээр авагдсан ба дүн мэдээгээр 53,5%-тай үнэлэгдсэн. Энэ хичээлийн жилд ЭЕШ-д 17 сурагч хамрагдаж. Нийт 17 төгсөгчөөс 17 сурагч буюу 100% их, дээд сургуульд элсэн суралцсан. ЭЕШ-ын дундаж оноо 452 байв. -Дээд оноо 603 -Доод оноо 336 оноотой байлаа. ЭЕШ-ын шалгалтын оноогоор сурагч Б.Анударь, М.Баярмаа, Б.Номин-Эрдэнэ, Т.Хулан нар</p>	95%

<p>Орхон аймгийн хэмжээнд байгалийн ухааны хичээлийн дундаж оноогоор 2024 оны "Ерөнхийлөгчийн тэтгэлэг" онооны болзол хангасан. Улсын хэмжээнд С.Анударь шалгарч ерөнхийлөгчийн тэтгэлгээр суралцахаар болсон.</p>						<p>"Чадварлаг багш" үзэсгэлэн гаргах</p>	<p>4</p>
<p>"Багш" хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багшийг урамшуулах зорилгоор "Чадварлаг багш-2024" үзэсгэлэнг</p> <p>1.Багшийн арга зүй технологийн зураглал, танилцуулга, үр дүн</p> <p>2.Цахим болон цаасан, гарын доорх материал ашиглан боловсруулсан сургалтын хэрэглэгдэхүүн</p> <p>3.Үнэлгээний дасгал, даалгавар гэсэн 3 төрлөөр зохион байгуулсан.</p> <p>Тус уралдаанд Багш И.Норжмаа, Ж.Бямбасүрэн, Д.Ганцолмон нар оролцож цахим болон цаасан гарын доорх материал ашиглан боловсруулсан сургалтын хэрэглэгдэхүүн төрлөөр оролцсон.</p> <p>3-р цөцэрлэг нь 2023-2024 оны хичээлийн жилд "Байгаль-Нийгмийн орчин" сургалтаар СМТ-д үзэсгэлэн гаргасан, 2024-2025 оны хичээлийн жилд "Эрүүл аюулгүй-Миний цөцэрлэг" үзэсгэлэнг гаргаж ажилласан. 2 удаагийн үзэсгэлэнд 8 багш, 6 багшийн</p>			<p>ЕБС-ийн 3 багш СӨБ-ийн 15 багш, ажилтан үзэсгэлэн гаргасан</p>	<p>Сөб 2 удаа үзэсгэлэн гаргаж 189 иргэн хамрагдсан</p>	<p>2023 он</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар</p>	<p>"Чадварлаг багш" үзэсгэлэн гаргах</p>	<p>90%</p>

									туслах, 10 ажилтан нийт- 24 багш, ажилчид, 142 эцэг эх, оролцсон. Цэцэрлэгт нийт 9,758,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. Үзэсгэлэнг сумын нийт - 189 иргэн үзэж танилцсан.	
2. БАГШ, АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР.										
5	Эрүүл мэндийн үзлэг оношилгоонд нэгдсэн журмаар хамруулах, төлбөрийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх	Хамрагдалтын хувь	2023 он	2023,2024 онуудад 12 төрлийг үзлэг шинжилгээнд Орхон Энэ дагуу нийт 7.179.000 мянган төгрөг тус тус зарцуулагдсан ба	100%	3.437.000	Эрүүл мэндийн дэмжих зардлаас	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны "Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай" А/238, А/340 дүгээр тушаалын хүрээнд "Багшийн эрүүл мэндийг дэмжих зардлаас" Орхон аймгийн БОЭТ-д 12 төрлийг үзлэг шинжилгээнд 3.437.000 төгрөгөөр 34 багшийг хамруулахаар гэрээ байгуулсан. Үзлэг шинжилгээнд 30 багш хамрагдаж 88% тай байна. 2024-2025 оны хичээлийн жилд Баян-Өндөр мед эмнэлэгтэй 3.742.000 төгрөгөөр 31 багшийг үзлэг шинжилгээнд хамруулахаар гэрээ байгуулан ажиллаж байна. 3-р цэцэрлэг нь 2024-2025 оны хичээлийн жилд БОЭТ-д нийт 29 багш ажилтан шинжилгээнд хамрагдан. Мөн Баян-өндөр мед эмнэлэгт 7 багш, 6 багшийн туслах, 4 удирдах ажилтан нийт 17 ажилтныг мэргэжлийн чиглэлээр шинжилгээнд хамруулан ажилсан нийт зардал 967,000 төгрөг.	90%	
6	Багш ажилтны хүн амын дунд зонхилж	Сургалт зохион байгуулсан тоо	2023 он	10 удаагийн	100%	-	-	Жаргалант сумын ЭМТ-тэй хамтран 3, НТБТ-тэй хамтран 4	85%	

	буй өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2023 он	5 удаагийн сургалт зохион байгуулсан	100%		Батшин хөгжлийг дэмжих зардлаас	Боловсролын ерөнхий газраас 2024 оны 1-р улиралд нийт багш, ажилтан албан хаагч нарын хөгжлийг дэмжих зорилгоор зохион байгуулсан "Багшийн хөгжлийг дэмжих модуль сургалт"-д 35 багш, ажилтан хамрагдахаас 26 албан хаагч хамрагдаж БАТЛИАМЖ гардан авсан.	удаа сумын ЗДТГ-тай хамтран 1 удаа, Байгууллага дээр эмч 3 удаа нийт- 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 178 багш ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх сургалтад хамруулан ажилласан.
3. БАГШИЙН НЭР ХҮНД, ҮНЭЛЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:										
7	Багш, ажилтныг ёс зүй харилцаа хандлагыг дээшлүүлэх, манлайллыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2023 он	5 удаагийн сургалт зохион байгуулсан	100%		Батшин хөгжлийг дэмжих зардлаас	Мөн ЕБС, Цэцэрлэгийн "Ёс зүйн дэд хороо" ёс зүйн тухай хууль болон ёс зүйн тухай журмыг танилцуулан төлөвлөгөөгөө баталгаажуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд байгууллага тус бүр 3 удаа сургалт явуулж нийт давхардсан тоогоор нийт ЕБС- 145, Цэцэрлэг-45 багш, ажилтан хамрагдсан. 2024 онд ЕБС-д 3 гомдол санал, Цэцэрлэгт-0 санал ирсэн байна. Тус санал гомдлын журмын дагуу шийдвэрлэн ажилласан.	95%
8	Дутагдалтай байгаа багш, боловсон хүчний судалгаа дээр үндэслэн МУБИС-тай хамтран ажиллах үйл		Математикийн сонгон шалгаруулалт	2023 он	Сонгон шалгаруул алтын зар 4 удаа зарлагдсан	100%		-	2024-2025 оны хичээлийн жил математикийн багш Э.Ичинхорлоо жирэмсний амралт болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд математикийн багшийн	85%

	ажиллагаа зохион байгуулах					Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2023 он	6 арга хэмжээ хэрэгжүүлж 30 гаруй багш хамрагдсан байна.	100%		дутагдалтай байгаа бөгөөд сонгон шалгаруулалт зарлагдсан боловч материал ирээгүй бөгөөд хичээл сургалтад хоцрогдолт үүсгэхгүйн тулд дотоод нөөц бололцоогоо ашиглан сургалтын үйл ажиллагааг 100% явуулж байна. 3-р цэцэрлэг нь 2024-2025 онд Орон тоо шинэчлэгдэн нийт 29 багш ажилтантайгаар ажиллаж байна. Биеийн тамир багш-1, Сантехникч-1, Нягтлан бэлтгэгч-1, нийт 3 орон тоо нэмэгдсэн. Дутагдалтай орон тоо байхгүй.
9	Багш мэргэжлийг олон нийтэд сурталчлах					Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2023 он	6 арга хэмжээ хэрэгжүүлж 30 гаруй багш хамрагдсан байна.	100%	Багшлахуйн арга зүй, бүтээлч туршлагуудыг хуваалцан, түгээн дэлгэрүүлэх зорилготой арга зүйд суурилсан "УРИЛГАТ" хичээлийг бага ангийн багш А.Оюунаа, МХУЗ-ын багш Д.Ганцолмон, физикийн багш Б.Мөнгөнтуяа нар зохион байгуулж тэргүүн туршлага, ололт амжилтыг залуу багш нар нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлсэн. Тус үйл ажиллагааны хүрээнд нийт багш нарын 65% нь арга зүй, туршлага ахиулсан амжилттай ажиллаа.	
										3-р цэцэрлэг нь багшийн мэргэжлийг олон нийтэд сурталчлах ажлыг байгууллагын хэмжээнд чанартай зохион байгуулан Багш Ч.Агиймаа, хөгжмийн багш Б.Энхтүвшин нар өөрсдийн арга зүй, тэргүүн туршлага олон нийтэд болон залуу багш нар түгээн дэлгэрүүлэн ажилласан. Нийт -	

									180 гаруй эцэг эх, олон нийт иргэд оролцсон. Багш Ч.Агиймаа ЗААХ аргач багшаа бататгасан бол, Хөгжмийн багш Б.Энхтүвшин Заах аргач багш зэргээ авсан. Нийт зэрэгтэй багшийн тоо 1 нэмэгдэж 5 болсон.	
ХОЁР. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ХЭРЭГЛЭГЧ БОЛСОН СУРАЛЦАГЧДЫН СУРЧ ХҮМҮҮЖИН, ХӨГЖИХ ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ, ТЭДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОЛЦООНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ.										
4. СУРАГЧДЫН СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР.										
10	Сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг "Хүүхэд хамгааллын баг"-тай хамтарсан зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2023 он	10 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 480 гаруй хүүхэд хамрагдсан байна.	100%	-	-	2023-2024 оны хичээлийн жилд хүүхэд хамгааллын багт ирсэн болон илрүүлсэн кейс нийт 23 байснаас нөхцөл байдлын үнэлгээгээр "Хүнд" 5 кейстэй сумын хамтарсан багтай хамтарч ажиллаж кейс нээж төлөвлөлт хийж, үйлчилгээ үзүүлэн 4 хааж, хяналтад 1 кейстэй ажиллаж байна. Дунд 11 кейстэй сургуулийнхаа хамтарсан баг сэтгэл зүйчтэй хамтран ажиллаж хаасан 7 хөнгөн кейсд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ, зөвлөгөө үзүүлсэн. Аймгийн хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын хүнд кейсийн, эрсдэлт 9 настай сурагчийг түр хугацаагаар дотуур байранд суулган хичээл сургалтыг завсардуулахгүй сурган хүлээлгэн өгсөн.	100%	
									Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газраас хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ авч дараах сургалт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан Үүнд:	

	<p>-АУБ нарт Хүүхэд хамгаалалд анги удирдсан багшийн оролцоо сургалт- 2 удаа нийт 29 багш</p> <p>-Эцэг эхчүүдэд "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалт 3 удаа 309 эцэг эх хамрагдсан</p> <p>-Хүүхэд хамгааллын багт, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх 2 удаа 9 багш удирдлага хамрагдсан</p> <p>-Movie event- ярилцлага Өсвөр насны хүүхдүүдэд 184 сурагч хамрагдсан</p> <p>-“Зоригтой хайр” контент зураг авалт, хүүхэд асран хамгаалагчтай ярилцах 5 сурагч эцэг эхтэйгээ</p> <p>-Жаргалант ЕБС-ын ХОБ - Д зөвлөн туслах үйлчилгээ 5 ХОБ ,оролцооны 102 сурагч</p> <p>-Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, сурагчид болон багш ажилтан асран хамгаалагч нарт -Гэр бүлд зөвлөгөө өгөх архины хамааралтай болон эрсдэлт нөхцөлийн гэр бүлд 5 гэр бүлд гэр айлчлал хийж зөвлөгөө өгсөн</p> <p>-Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх 5 багш ажилтан</p> <p>-Хамтарсан багт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлчилгээнүүдэд нийт 254 сурагч 302 эцэг эх, асран хамгаалагч 53 багш ажилтан дээрх үйлчилгээ авсан.</p> <p>3-р цэцэрлэг нь Зорилтот бүлгийн хүүхдийн судалгаанд нийт 140 хүүхэд хамрагдсан</p>
--	--

11	Орон нутгийн түүхэн дурсгалт газар, ард иргэдийн ёс заншилтай танилцуулах зорилгоор ахлах ангид тусгай хөтөлбөрөөр "ЭКО" аяллыг жилд нэг удаа зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Оролцсон сурагчдын тоо	2023 он	3 үйл ажиллагаа зохион байгуулж 190 хүүхэд хамрагдсан байна.	100%			<p>Үүнээс- Эрсдэлт бүлгийн-1, Эмзэг бүлгийн-3, Тавиул-11, Малчин өрхийн-22 хүүхэд тус тус хамрагдсан. Багш, багшийн туслах нар Зорилтот бүлгийн хүүхдүүдийг өдөр бүр ажиглалт хийж тэмдэглэл хөтлөн тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нартай хамтран эргэх холбоотой ажиглаж байна. Сумын ИТХ-тай хамтран Жил бүр уламжлал болон зохион байгуулдаг "Эрүүл агаар эм" явган аяллыг зохион байгуулан явуулдаг явган аялалд 6 бүлгийн 78 эцэг эх, 15 багш ажилтан оролцож нийт 1,000,000 төгрөгийг зарцуулан ажилсан. Тухайн аяныг явуулснаар эцэг эхийн идэвх оролцоо нэмэгдэж, багаар ажиллах, хамтын ажиллагаа сайжрах, хүүхдүүдээ элдэв эрсдэлээс хамгаалах, өөрсдийн эрүүл мэндээ анхаарах, хүүхдээ эрүүл агаарт чийрэгжүүлэх зэрэг ажил дадал болж, хүүхдийн өвчлөл буурах, багш, эцэг эхийн хооронд гардаг үл ойлголцох асуудал байхгүй болсон.</p>	
								<p>2024-2025 хичээлийн жилд -7 дугаар ангийн сурагчид "Орон судлал" аяллын хөтөлбөрөөр 2024 оны 10 дугаар сарын 28-ний өдөр аймгийн музей, Уурхайчин соёлын ордон дахь цахим музей үзэх, ёс заншлын өргөө зэрэг маршрутаар 7-р ангийн 56 сурагч 2 багш хамрагдсан.</p>	100%

	ажлыг эрчимжүүлж анги бүрийн эцэг эхчүүдийг хамарсан хүүхдийнхээ сурлага, хүмүүжил, урлаг, спортыг хөгжүүлэх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор улиралд 1 удаа Лекторуудыг урьж сургалтад хамруулах		байгуулж давхардсан тоогоор 340 гаруй асран хамгаалаг оролцсон	2024 оны 4 сард зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 1-12 ангийн давхардсан тоогоор 320 гаруй асран хамгаалагч оролцсон. Өдөрлөгийн үеэр дараах өгсөн. Үүнд: -Сургуулийн нэгдсэн мэдээлэл -Сургалтын талаар мэдээлэл -Хоцрогдол арилгах хөтөлбөр -Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулга -Үдийн хоол хөтөлбөрийн танилцуулга -Санал хүсэлт авах, -Томуу томуу тест өвчнөөс сэргийлэх нь -Сонгон секц дугуйлан, зэргийг таниулан -АУБ нар асран хамгаалагч нартай уулзалт хийж санал хүсэлтийг нь авч асран хамгаалагч нар хүүхдийнхээ сурлага хүмүүжлийн талаар мэдээлэл авлаа.
--	---	--	--	---

ДӨРӨВ. БАГШ АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, АЖИЛЛАХ НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НЭМЭГДҮҮЛЭХ
6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

13	Багшийн хөгжлийн төвийг стандартын дагуу тохижуулах	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	2018 онд Орхон аймгийн ОНТ-өөр 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалта ар багш хөгжлийн төвд ширээ сандал нийлүүлэгдсэн 50%	100%	120.0 сая	ОНТ	Тайлант хугацаанд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар багшийн хөгжлийн төвд их завсар хийгдсэн. Мөн багш нарын цахим орчинд ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор 4,1 сая төгрөгөөр дотоод сүлжээний тохижилт үйлчилгээний ажил, 15,0 сая төгрөгөөр канон-1 ширхэг, принтер А3-2 ширхэг, неүтбүүк-2 ширхэг, Улсын 16,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 82 инчийн ухаалаг	100%
----	---	---------------------------	---------	--	------	-----------	-----	---	------

14	Эрэгтэй технологийн кабинетыг тавилга эд хогшлоор хангах	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	2020 онд багш дэд хөтөлбөрөс 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЮНИМАТ, AR тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн	100%	120.0 сая	ОНТ	дэлгэц тус тус нийлүүлэгдэж ажиллах орчин, нөхцөл сайжирсан. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургуулийн 30 багшид таблет олгогдсон. Орон нутгийн хөгжлийн сангийн 120,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулийн "Эрэгтэй хөдөлмөрийн кабинетэд их засвар хийх" ажлыг "Смайл хаус" ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн 14,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 17 төрлийн тавилга эд хогшил, гар багаж нийлүүлэгдэж дунд, ахлах ангийн эрэгтэй сурагчдыг технологийн хичээлийн сургалтаар хүүхэд бүрийг хөгжүүлэх, амьдрах ухаанд бэлтгэх, бүтээлч чадварыг нэмэгдүүлэх орчин нөхцөл бүрдсэн.	100%
15	Ангийн самбар /5ш/	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	75%	100%	8.0 сая	ОНТ	Орон нутгийн хөгжлийн сангийн 8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бага, дунд ангиудад нэн шаардлагатай байсан 5 ширхэг самбар нийлүүлэгдсэн.	100%
16	Сургуулийн "Урлаг заал"-ны сандлаар хангах	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	2017 онд ОНТ 28 сая хөрөнгө оруулалтаар урлаг заалны дээврийн болон	100%	47.0 сая	ОНТ	Орон нутгийн хөгжлийн сангийн 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар урлаг зааланд 102 ширхэг сандал нийлүүлэгдсэн. Мөн 27 сая төгрөгөөр гитар-2 ширхэг, хөлтэй-1 даралтад хөгжим хөлтэй-1 ширхэг, пульт өсгөгч-2 ширхэг, яригч-1 микрофон	100%

20	ЕБС-ийн зааланд шаардлагатай спортын хэрэглэгдэхүүн	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	дэвэрийн болон дотор засвар хийгдсэн. 65%	100%			хичээл болон дугуйлан, секц зохион байгуулах орчин нөхцөл сайжирсан. Нийт давхардсан тоогоор 250 гаруй сурагч 6 төрлийн дугуйланд хамрагдаж байна.	
21	Дуу хөгжмийн хичээл болон урлаг зааланд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	2016 онд дэлхийн зөн ОУ байгууллаг аас30 ШИРХЭГ ӨСГӨГЧ, БУСАД ТОНОГ ТӨХӨӨРӨ МЖ 4.8 САЯ	100%	27.0 сая	ОНТ	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 27,0 сая төгрөгөөр дуу хөгжмийн хичээлийн болон урлаг зааланд шаардлагатай байсан цахилгаан гитар-2ш, даралтад хөгжим-1ш, пульт өсгөгч-2, чанга яригч-1ш, микрофон холбогч Утаснууд тус тус нийлүүлэгдэж урлагийн уралдаан тэмцээн, бусад сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах таатай орчин, нөхцөл бүрдсэн. Нийт 80 гаруй сурагч 3 төрлийн дугуйланд хамрагдаж байна. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар 10 ширхэг морин хуур нийлүүлэгдэж 10 сурагч дугуйланд хамрагдаж байна.	100%
22	Багш, ажилтан нарын хувцасны шүүгээ	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	45%	100%	17.4 сая	ОНТ	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Боловсрол хөтөлбөрийн хүрээнд "Бага ангийн хүүхэд хөгжлийн танхим"-ыг 17,4 сая төгрөгний өртөг бүхий кабинетыг Сэнгүн констракшн ХХК хийж гүйцэтгэсэн.	100%

23	Бага ангийн сурагчдын гадуур хувцас хийх 6 нүдтэй төмөр шкаб хэрэгцээтэй байгаа 25ш	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	2023 онд бага ангийн 6 бүлэгт 17.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хувцасны шүүгээ	100%	15 сая	ОНТ	Хөрөнгө оруулалтын зардлын 15,0 сая төгрөгийн санхүүжилтээр Ерөнхий боловсролын сургуулийн "Бага бүлгийг хувцасны шкафаар хангах" ажлыг хийж гүйцэтгэн 5 бүлэгт 25 ширхэг хувцасны шүүгээ нийлүүлэгдэж нийт бага ангийн 11 бүлэг шүүгээтэй болсон бөгөөд сурагчдын нас, биеийн хөгжлийн онцлог, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчин нөхцөл бүрдсэн.	100%
24	"ДИЗАЙН СУРГУУЛЬ" төсөл 1 багш 20 сурагч	Хамрагдсан сурагчдын тоо Хэрэгжилтийн хувь	2023 он	20 сурагч хамруулах	100%	-	ОНТ	"DESIGN SKOOL" сургалтын байгууллагатай хамтран "DIGITAL ART, INTERIOR DESIGN" чиглэлээр логик сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор 2023-2024 оны хичээлийн жилд 20 сурагч хамрагдаж төгссөн. Хөтөлбөр хэрэгжсэнээр сурагчдын бүтээлч сэтгэхүй хөгжиж, энгийн хэрэглээнээс мэргэжлийн түвшинд суралцаж суурь болон хөгжих боломж бүрдэж байна.	100%
25	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд спорт зааланд үзэгчдийн сандал, хэсэгчилсэн дотор засвар хийх	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	30%	100%	170,0	ОНТ	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалтын зардлын 170,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Спорт зааланд үзэгчдийн сандал хийх, хэсэгчилсэн дотор засвар"-ын ажил хийгдэж байна. Уг засварын ажлын хүрээнд зөөх боломжтой үзэгчдийн сандал, сангийн ажил, хэсэгчилсэн засвар, паар солих, хувцасны өрөөг засварлах, явган хүний зам тавих зэрэг ажлууд хийгдэж иргэд ая тухтай орчинд спортын	100%

26	3-р цэцэрлэгийн Урлаг заалны засвар	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	50%	100%			Тэмцээн уралдаан үзэх орчин бий болж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Боловсрол хөтөлбөрийн хүрээнд 3-р цэцэрлэгийн "Урлаг заалны засвар"-ыг 55,3 сая төгрөгөөр завсар хийгдэж. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэгдсэн.	100%	
27	3-р цэцэрлэгийн Урлаг зааланд шаардлагатай тоног төхөөрөмж, тоглоом худалдан авах	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2023 он	50%	100%	ОНТ	55.3 сая	Урлаг зааланд их засварын ажил, 19 төрлийн 65 ширхэг хөгжмийн зэмсэг, 8 нэр төрлийн 87 ширхэг тоглоом, 26 ширхэг хувцасны шүүгээ, гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэгдэж сургалт, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл сайжирсан. Нийт сурагчдын 60 хувь буюу 54 хүүхэд 3 төрлийн дугуйланд хамрагдаж байна. 6 бүлэгт 8 нэр төрлийн тоглоом тэр дундаа сэдэвт тоглоомтой болсноор хүүхдүүдийн цэцэрлэгт ирэх хүсэл сонирхол нэмэгдэж, хэл ярианы хөгжил сайжран, хийсвэр сэтгэлгээ хөгжиж байна.	100%	
ДҮН									97.7%	85.9%
2021-2024 ОНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ										

**ТАЙЛАН ГАРГАСАН: ЕБС, ЦЭЦЭРЛЭГ
БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛЭЭ**

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээ
1	БОЛОВСРОЛ- ЕБС, ЦЭЦЭРЛЭГ	4	27
	Нийт	4	27

Орхон аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/750 дугаартай захирамж” Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Жаргалант сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд нийт 25 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажилласан байна. Үүнд:

- Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрсэн **100 хувьтай 20 арга хэмжээ**
 - Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол **90-95 хувьтай 54 арга хэмжээ**
 - Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол **85 хувьтай 2 арга хэмжээ**
 - Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувьтай **1 арга хэмжээ**
- НИЙТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ 97,7% БАЙНА.**